

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛЬ



2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

ОРОС ХЭЛНИЙ БАГШ БУЯДАА ОВОГТОЙ АЛТАНХУЯГ

2019 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН ОРОС ХЭЛНИЙ БАГШ Б.АЛТАНХУЯГИЙН
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

I. ТӨЛӨВШИЛ

1. Сургуулиас зохиогдсон олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог. Үүнд:
 - ❖ Хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсон.
 - ❖ Спорт буухиа-2018-д З.Тунгалаг ахлагчтай багийн бүрэлдэхүүнд орж 3р байр эзэлж “Хүрэл” медаль авсан.
 - ❖ Орос хэлний дүүрэг, нийслэлийн олимпиадад 9а ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулсан, мөн өөрөө амжилттай оролцсон. Дүүргийн Орос хэлний олимпиадад 9а ангийн сурагч Б.Пунцагмаа 1р байр “Алтан” медаль, О.Намуунбилэг 2р байр “Мөнгөн” медаль, Э.Дөлгөөн 3р байр “Хүрэл” медаль, А.Амирлан шагналт 4р байр тус тус эзэлсэн болно. Нийслэлийн Орос хэлний олимпиадад Б.Пунцагмаа шагналт 4р байр эзэлж Улсын Орос хэлний олимпиадад орж “Батламж” авсан. Би өөрөө Дүүргийн Орос хэлний олимпиадад 1р байр “Алтан” медаль, Нийслэлийн Орос хэлний олимпиадад 2р байр “Мөнгөн” медаль, мөн Улсын Орос хэлний олимпиадад орж “Батламж” авсан.
 - ❖ Сургуулийн багш нарын баярын үйл ажиллагаанд оролцсон.
 - ❖ Багш нарын нэгдсэн хуралд оролцсон.
 - ❖ “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?” зөвлөмж хичээлийг, “Шударга ёс” – ны хичээлийг 2018оны 10р сарын 5аас 2019 оны 5р сарын 24ны өдөр хүртэл хичээлээс гадуур үйл ажиллагааны цаг дээр орсон болно.
 - ❖ “Авъяаслаг 23” Урлагийн наадамд удирдсан 9а ангиа бэлтгэн амжилттай оролцуулж суурь боловсролын “Шилдэгийн шилдэг” ангиар шалгарч “Гранпри” “Шилжин явах цом”- оор шагнуулсан.
 - ❖ “Хоцрогчгүй, таслагчгүй хамт олон” аянд оролцож нэг удаа 3р байр эзэлж өргөмжлөл авсан.
 - ❖ Мөсөн хотхоны нээлтийн үйл ажилгаанд оролцсон.
 - ❖ Шинэ жилийн үйл ажиллагаанд оролцсон.
 - ❖ Чингэлтэй дүүргийн орос хэлний олимпиадыг сургууль дээрээ зохион байгуулах ажилд оролцсон.
 - ❖ Голомт банкнаас зохион байгуулсан санхүүгийн боловсролыг дэмжих аянд 9а ангиа амжилттай хамруулсан.
 - ❖ Цагаан сарын золголт дээр ирж золголт хийсэн.
 - ❖ “Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөр” үйл ажиллагаанд 3а, 4а, 5ө, 7а, 7в, 9а, 10а, 11а ангиудын эцэг эхтэй 7өдөр уулзсан.
 - ❖ ОШУСТ-өөс зохион байгуулсан “Тотальный диктант” ОУ-ын үйл ажиллагаанд 7а, 9а, 10а, 11а ангийн сурагчдаа оролцуулж мөн өөрөө 2дахь жилдээ оролцсон. Энэ үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж, энэ жил 16дахь удаагаа Дэлхийн 60-аад оронд зэрэг явагдсан болно.
 - ❖ 3а ангийн Орос хэлний үсэглэлийн баярыг амжилттай зохион байгуулсан.

- ❖ Хэлний өдөрлөгт Орос хэлний ангийн сурагчидаа өргөнөөр хамруулсан. “Мой город” сэдэвтэй зохион бичлэгийн уралдааныг зарлаж ялагчдыгаа тодруулсан.
- ❖ Хэлний наадам-2019 т Орос хэлний ангийн сурагчидаа өргөнөөр хамруулсан.
- ❖ 8-12-р ангийн сурагчдыг орос хэлний ОУ-ын түвшинчлэлийн шалгалтыг 2 хагас сайн өдөр дамнуулан авч, шалгаж, анализ хийсэн.
- ❖ “Эртэч хүүхэд -2” аяны хүрээнд даасан 9а ангиа амжилттай оролцуулсан.
- ❖ “Цэнэглэх цаг” бүрийг алгасалгүй сууж оюунаа цэнэглэсэн.
- ❖ Сар бүрийн жижүүр багшийн үүргээ хариуцлагатай гүйцэтгэдэг /Энэ хичээлийн жилд сар бүр жижүүр багшийн үүргийг гүйцэтгэж жижүүр багшийн үнэлгээний хуудсаа хариуцлагатай жижүүрээсээ авч дүгнүүлсэн. Авбал зохих 30 онооноос дандаа 30оноогоо авч чадсан. /
- ❖ 5ё ангийг Дунд ангид шилжин орох ёслолын үйл ажиллагаанд нь “Хэрвээ сайхан амьдарч байвал” дууг бэлтгэн оролцуулсан.
- ❖ Дүүргийн гадаад хэлний багш нарын ур чадварын уралдаанд оролцсон 5р сургуулийн Орос хэлний багш Эрдэнэчимэг, 117р сургуулийн багш Туяа нарын нээлттэй хичээлд сууж ажиглалт хийсэн.
- ❖ Мэдлэг чадварын сорил, анги дэвших шалгалтыг ангиудаас авч анализ хийсэн.
- ❖ РЦНК-аас болон сургуулиас зохион байгуулсан сургалт семинарт сууж мэргэжлээ дээшлүүлсэн.
- ❖ Квон У Сог багшийн “Moodle” системийн сургалтанд хамрагдаж шалгалтанд 92% р тэнцэж “СЕРТИФИКАТ” гардан авсан.
- ❖ Квон У Сог багшийн “Moodle” системийн сургалтанд Эцэг эхчүүдээ хамруулсан.
- ❖ Завхан аймгийн Орос хэлний багш нарт “Ухаалаг самбар” ашиглаж “Moodle” систем дээр цахим нээлттэй хичээл заасан.
- ❖ “Анги удирдах урлаг” анхдугаар зөвлөгөөнд оролцсон.
- ❖ Ангийн дарга нарын анхдугаар зөвлөгөөнд оролцсон.
- ❖ Эцэг эхчүүдийн анхдугаар зөвлөгөөнд оролцсон. Дээрх гурван зөвлөгөөнөөс гарсан уриалгыг даган мөрдөн ажилласан. Даасан 9а ангийн сурагчдын бүх дэвтэрт “Дунд ангийн сурагчдаас гаргасан уриалгыг” хэвлэн наалгасан.
- ❖ Бүх нийтийн мод тарих өдөрт оролцсон.
- ❖ Бүх нийтийн “Их цэвэрлэгээний өдөр” ирж ажилласан.

2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал

- ❖ Сурагчдад хичээлийн дэг, завсарлагааны дэгүүдийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажилладаг, Ангийн булан дээр гаргаж хадсан.
- ❖ Сурагчид гэрийн даалгавраа шалгаж хэвшсэн.
- ❖ Ангийн ариун цэвэрт анхааран ангийн агааржуулалтыг байнга ажиллуулдаг.

- ❖ Кабинет хоорондоо явахдаа баруун гараа даган жагсаж хичээлдээ явдаг.
 - ❖ Даасан 9а ангийн сурагчид, тэдний эцэг эхэд сургууль дээр мөрдөх дэгийг нэг бүрчлэн танилцуулж, дэгийг баримтлан ажилласан.
 - ❖ Ухаалаг утас сургууль дээр хэрэглэхгүй байх, охидууд үсээ боох, завсарлагааны үеийн дэгийг сахих, хичээл эхлэхээс 10 минутийн өмнө ангидаа орж байраа эзэлсэн байх, хичээлд хоцрохгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр хичээл таслахгүй байхад анхаарч ажиллалаа. Дэгийг мөрдөж ажилласнаар хоцрогчгүй хамт олон болон 1 удаа БАТЛАМЖ гардсан авсан.
 - ❖ Хичээл орж буй 3а, 4а, 5ё, 7а, 7в, 9а, 10а, 11а ангиудад дараахи дэгүүдийг мөрдөхөд анхаарч ажиллалаа.
 - ❖ Хичээлийн 40 минутын дэг
 - ❖ Сурагчийн дэг
 - ❖ Завсарлагааны дэг
 - ❖ Цайны газрын дэг
 - ❖ Өлгүүрийн дэг
3. Бусадтай харилцах зан чанар
- ❖ Дүрэмт хувцсаа тогтмол бүрэн өмсөхөд хэвшүүлсэн.
 - ❖ Хичээл эхлэхээс өмнө ангиа, самбараа арчиж бэлдсэн байх
 - ❖ Багш ангид орж ирэхэд эмх цэгцтэй байх, үймүүлж шуугихгүй байхад хэвшүүлж байна.
 - ❖ Хичээлийн дэгийг баримталж, ярих, бусдад саад болохгүй байх, бие биенийхээ үгийг сонсох, нэгнийхээ шаардлагыг хүлээж авах, хүндэтгэлтэй хандах, талархалаа илэрхийлэх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй, ангийн даргын үүрэг даалгаврыг биелүүлэх зэрэгт анхаарч ажиллаж, хэвшүүлсэн.
 - ❖ Мэргэжлийн багш нар, аж ахуйн ажилчид, үйлчлэгч нартай мэндэлж байх, тэдний ажлыг хүндэтгэх.
 - ❖ Хамтран суралцах, бие биедээ туслах, мэддэг зүйлээ хэлж өгөх зэрэг нь сурагчдын сурах сонирхлыг төрүүлж, эвсэг, зорилго нэгтэй хамт олон бүрэлдэх түлхэц болсон.
4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал
- ❖ Орос хэлний дүүрэг, нийслэлийн олимпиадад 9а ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулсан, мөн өөрөө амжилттай оролцсон. Дүүргийн Орос хэлний олимпиадад 9а ангийн сурагч Б.Пунцагмаа 1р байр “Алтан” медаль, О.Намуунбилэг 2р байр “Мөнгөн” медаль, Э.Дөлгөөн 3р байр “Хүрэл” медаль, А.Амирлан шагналт 4р байр тус тус эзэлсэн болно. Нийслэлийн Орос хэлний олимпиадад Б.Пунцагмаа шагналт 4р байр эзэлж Улсын Орос хэлний олимпиадад орж “Батламж” авсан. Би өөрөө Дүүргийн Орос хэлний олимпиадад 1р байр “Алтан” медаль, Нийслэлийн Орос хэлний олимпиадад 2р байр “Мөнгөн” медаль, мөн Улсын Орос хэлний олимпиадад орж “Батламж” авсан.
 - ❖ “Цайны их замаар” ОУ-ын хүүхдийн наадамд сурагчдыг илтгэл, гар зураг, IQ төрлөөр амжилттай оролцуулсан.
 - ❖ Дэлүүн болдогийн “Гэгээн зөн” яруу найргийн тэмцээнд 3 сурагч амжилттай оролцсон.

- ❖ “Авьяслаг 23” Урлагийн наадамд удирдсан 9а ангиа бэлтгэн амжилттай оролцуулж суурь боловсролын “Шилдэгийн шилдэг” ангиар шалгарч “Гранпри” “Шилжин явах цом”- оор шагнуулсан.
- ❖ Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж ханын сонин гаргасан.
- ❖ “Цахим хэрэглээ бидний амьдралд” ханын сонингийн уралдаанд орж батламж авсан.
- ❖ “Ухаалаг утасны зохистой хэрэглээ” бүх эцэг эхчүүдэд танилцуулж гарын үсэг авсан.
- ❖ Ангийн дарга нарын анхдугаар зөвлөгөөнд “Бид өөр өөр ертөнц” сэдэвт илтгэлийг ангийн дарга Б.Марал, Ангийн IT инженер Т.Үйзэн нар уншиж, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн оролцсон.
- ❖ Голомт банкны санхүүгийн боловсрол олгох, “Хуримтлалыг багаас нь” сургалтыг ангидаа авч, 18 сурагч хуримтлалын дэвтэр нээлгэсэн.
- ❖ 9а, 10а ,11а, 12а ангийн сурагчид “Читаем Пушкина на разных языках” уралдаанд Монгол, Орос, Англи, Япон, Солонгос, Хятад хэл дээр уншиж оролцсон болно. Тус уралдаан сургууль дээр РЦНК дээр тус тус болсон.

5. Жижүүр багшийн үнэлгээ

- ❖ Жижүүр багшийн үүргийг энэ хичээлийн жилд 8 удаа хийж гүйцэтгэсэн.
- ❖ /Энэ хичээлийн жилд сар бүр жижүүр багшийн үүргийг гүйцэтгэж жижүүр багшийн үнэлгээний хуудсаа хариуцлагатай жижүүрээсээ авч дүгнүүлсэн. Авбал зохих 30 онооноос дандаа 30оноогоо авч чадсан. /

6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал

Ангийн сурагчдаас дараахи судалгааг авлаа.

- ❖ Дэлгэрэнгүй судалгаа
- ❖ Эрсдлийн судалгаа
- ❖ Мэргэжлийн чиг баримжааны судалгаа
- ❖ Авъяас сонирхлын судалгаа
- ❖ Автобусны судалгаа
- ❖ Цахим хэрэглээний судалгаа
- ❖ Анги болгоноос гарааны үнэлгээ авч анализ хийн ажилласан. Мөн хоцрогдсон сурагчидтай ажилласан.

7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн

- ❖ Багш-эцэг эх-сурагчийн гурвалсан гэрээ байгуулж, хагас жил, жилийн эцсээр дүгнэн ажиллаж байна.
- ❖ Ухаалаг утас сургуулийн орчинд хэрэглэхгүй байх заавар зөвлөмжийг эцэг эхэд танилцуулан сурагчдын 81% нь товчлууртай утас хэрэглэх буюу ухаалаг утсаа сургууль дээр авч ирэхгүй болсон.
- ❖ “Авьяслаг-23” сургуулийн урлагийн наадамд бэлтгэх ажил, хувцасны жигдрэл гэх мэт бүх л ажлыг эцэг эхчүүд хариуцан ажилласан.
- ❖ Эцэг эхийн анхдугаар зөвлөгөөнөөр О.Намууны ээж Сүхбаатар “Эцэг эх гэж хэн бэ? Сургууль, хүүхэд, багшийн хамтын ажиллагаанд таны үүрэг оролцоо” сэвдээр илтгэл бэлдсэн.

- ❖ Квон У Сог багшийн “Moodle” системийн сургалтанд Эцэг эхчүүдээ хамруулсан.
- ❖ Сургуулийн “School police”-ийн үүрэгт ажлыг хуваарийн дагуу сайн гүйцэтгэлээ. Эцэг эхийн ирц 100% байсан.
- ❖ Эцэг эхийн нээлттэй хаалга үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай сурагчдын жагсаалт гарган эцэг эхтэй нь уулзаж ярилцсанаар тухайн сурагчдад тодорхой хэмжээний өөрчлөлт гарсан.
- ❖ Эцэг эхийн нээлттэй хаалганы үйл ажиллагаанд ирж амжаагүй эцэг эхийг утсаар холбогдон уулзсан.
- ❖ Улаан шугам урьдчилан байдлаар эцэг эхчүүдэд танилцуулсан.

8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт

- ❖ Хүүхдийг дээрхэлтээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхний дарамтаас сэргийлэх, хамгаалах, багшийн зүгээс ёс зүй баримтлахад анхаарч ажиллалаа.

9. Гранд дизайны зорилго, зорилтын биелэлт

- ❖ Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд тэгш хамруулж, зөв хандлагад чиглүүлэн ажилласан. Хүүхдэд хайртай, бусадтай хамтран багаар ажиллах чадвараа хөгжүүлж, хариуцлагатай, сурагчдын түвшин, сонирхол хэрэгцээнд тохирсон хичээлийн хөтөлбөр хийж, эцэг эхтэй хамтран сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд хичээн оролцлоо.
- ❖ Сурагчдын өөрийн хөгжлийн төлөвлөгөөнд сургуулийн гранд дизайнд тусгасан заалтуудаас оруулж, дадал хэвшил болгоход зорин ажиллаж 1-р хагас жилд дүгнэсэн.

МЭДЛЭГ ЧАДВАР, АХИЦ, АМЖИЛТ

1. Гарааны болон оношлох үнэлгээ

4а, 7а, 9а, 10а, 11а -р ангийн гарааны үнэлгээний материал боловсруулж үнэлсэн.

1-р хагас жилийн мэдлэг чадварын сорилтын дүнгийн нэгтгэл

№	Анги бүлэг	Тоо	Түвшин							
			VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	4а	32	1	1	9	5	16	0	0	0
2	7а	25	2	8	5	4	3	3	0	0
3	9а	22	2	6	8	0	1	0	0	0
4	10а	23	1	6	5	6	3	2	0	0
5	11а	21	3	5	7	7	2	0	0	0
Нийт		123	9	26	34	22	25	5	0	0

Гарааны үнэлгээний сэдвийг өмнөх ангид үзэж байсан агуулгын хүрээнд боловсруулсан. Сурагчид зуны амралтаар зарим нэг агуулгыг мартсан байсан нь дүнгийн нэгтгэлээс харагдаж байсан. Үүнд дүн шинжилгээ хийж, анги бүрт мартагдсан дүрэм, үг зүйг сэргээн санах даалгавар хийлгэж мэдлэгийн бататгасан.

2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/

9-р ангийн 3-р улирлын 2 нэгж хичээлийн хөтөлбөр, 4 ээлжит хичээл, 5 тест боловсруулан оруулсан. Нээлттэй хичээлийн цахим хичээл оруулсан.

3. Стандарт хэрэгжилт

№	Анги бүлэг	Тоо	Түвшин							
			VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	3а	27	11	13	3	0	0	0	0	0
2	4а	32	6	11	12	3	0	0	0	0
3	7а	25	5	15	3	2	0	0	0	0
4	9а	22	19	3	0	0	0	0	0	0
5	10а	23	13	8	2	0	0	0	0	0
6	11а	21	4	15	2	0	0	0	0	0
7	5ё	28	17	11	0	0	0	0	0	0
8	7в	28	13	12	3	0	0	0	0	0
Нийт		206	88	88	25	5	0	0	0	0

4. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

- ❖ Орос хэлний хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө хийж, сурагчдын гарааны оношилгоо хийсэн.
- ❖ Мэргэжлийн дагуу дүүрэг, нийслэлийн сургалт, семинарт цаг тухайд нь хамрагдсан. ОХУ-ын Ростов на Дону хотын их сургуулийн багш нарын “Орос хэл заах арга зүй” 72 цагийн сургалтанд хамрагдаж, заах арга зүй, хэл зүйн дүрэм, унших даалгавар гүйцэтгэх хичээлд сууж, сертификат авсан.
- ❖ Сургуулийн сургалт, цэнэглэх цагт цаг тухайд нь суусан.
- ❖ Сургууль дээр хэрэгжиж байгаа Мүүдл системийг хэрэглэж суралцан ашиглаж эхэлж байна.
- ❖ Дотоод сүлжээ, ESIS.EDU.MN сайтад дүн оруулах зэрэг ажлыг тухай бүрт нь хийж гүйцэтгэсэн.
- ❖ Удирдан ажиллаж буй 9а ангийн сурагчдад зөв хандлага, төлөвшил олгох ажилд анхаарч ажилласан.

- ❖ Дэмжлэг хэрэгтэй сурагчидтай хамтран хичээллэсэн.

5. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн

- ❖ Орос хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 3а, 4а, 7а, 9а, 10а, 11а ангиудын 150 сурагч, хоёрдогч хэлбэрээр орос хэл судалж буй 5ё, 7в ангиудын 56 сурагч, нийт 206 сурагчид орос хэлний сургалтыг стандартын дагуу хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан өглөө. 3-11 ангид гүнзгийрүүлэн нийт 838 цаг, энгийн 159 цаг, нийт 997 цагийн хичээл заасан байна.

6. Журнал бичилт

- ❖ Анги удирдсан багшийн журналыг зааврын дагуу хөтөлж, сурагчдын дэлгэрэнгүй судалгаа, оношилгоо, ололт амжилтыг бичиж тэмдэглэлээ. Мөн дүнг нэгтгэн бичсэн.
- ❖ Багшийн тэмдэглэл хэсэгт хэрхэн оролцсон байдал, төлөвшилд ямар өөрчөлт гарсан зэргийг тухай бүрт бичиж тэмдэглэсэн.
- ❖ Журналаа дүрэм журмын дагуу бичиж, 7 хоног бүр сургалтын менежерт хураалган шалгуулдаг

7. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил

- ❖ Энэ хичээлийн жилд сурагчдын сурах идэвхи сонирхлыг өрнүүлэх, багшийн үйл ажиллагааг чанартай болгох зорилготой секцийн зүгээс шинэ сурах бичиг хэрэглэж эхэлсэн нь маш үр нөлөөтэй ажил болсон. 3-4-р ангид “Солнышко-1” сурах бичиг, дасгал ажлын ном, 5-р ангид “Солнышко-2” сурах бичиг, дасгал ажлын нос, 8-9-р ангид “Жили были” ахисан анхан шатны ном, ажлын дэвтэр, CD, 10-12-р ангид “Жили были” дундаас ахисан дунд шатны сурах бичиг, ажлын дэвтэр, CD хэрэглэсэн.
- ❖ НБГ-ын даалгаврын санд тавигдсан жишиг даалгаврын дагуу хичээл ордог ангиуд болон даасан 9а ангийн сурагчдыг анги дэвших шалгалтанд мэргэжлийн багштай хамтран бэлтгүүлсэн.
- ❖ “Эртэч хүүхэд -2” аяны хүрээнд даасан 9а ангиа оролцуулан, Улсын шалгалтаа амжилттай өгөхөд нөлөөлсөн.
- ❖ Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн асуудлууд дээр тохирсон шийдвэрүүдийг гаргасан.
- ❖ Сурагчдын мэдлэг чадварын ялгаатай байдлыг харгалзан үзэж, даалгаврыг оновчтой өгч, тулж ажилласан.
- ❖ “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?” зөвлөмж хичээлийг, “Шударга ёс” – ны хичээлийг 2018оны 10р сарын 5аас 2019 оны 5р сарын 24ны өдөр хүртэл хичээлээс гадуур үйл ажиллагааны цаг дээр орсон болно.
- ❖ Эцэг эхтэй уулзаж ярилцан, хамтран ажиллаж байсан.
- ❖ Шинэ үгийн толь бичгийн дэвтэр өөрсдөөр нь хөтлүүлдэг
- ❖ Хичээл болгоны эхний 5 минутын шинэ үгийн шалгалт амаар болон бичгээр
- ❖ 7 хоногт 1 удаа багийн бүтээлч ажил
- ❖ Ярианы цаг
- ❖ Сонсголын цаг

8. Хичээлд ордог сурагчдын хүртээмж

- ❖ Орос хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 3а, 4а, 7а, 9а, 10а, 11а ангиудын 150 сурагч, хоёрдогч хэлбэрээр орос хэл судалж буй 5ё, 7в ангиудын 56 сурагч, нийт 206 сурагчид орос хэлний сургалтыг стандартын дагуу хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан өглөө. 3-11 ангид гүнзгийрүүлэн нийт 838 цаг, энгийн 159 цаг, нийт 997 цагийн хичээл заасан байна. Группээр ордог ч нийт ангийн хүүхдийн тоо их учир зарим ангиудад хичээл ороход хүндрэлтэй тал гардаг. Хүүхэд нэг бүрт хүрч ажиллахад анхаарч гэрийн даалгавар хийлтийг тогтмолжуулах, хичээлийн явцыг хичээл бүр дээр шалган үнэлэхээр хичээн ажиллалаа. Шаардлагатай үед ангийн багшаар дамжуулан эцэг эхтэй холбогдон хамтран ажиллахыг зорилго.
- ❖ Хичээлээ хүртээмжтэй явуулахын тулд 7 хоногийн 3 оролтныхоо 1 цагийг ярианы болон багийн бүтээлийн хичээл болгон зохион байгуулсан.
- ❖ Сурагчид харилцан яриа цээжлэн, түүнтэй адил харилцан яриа зохиож найзууддаа ярьж өгсөн.

9. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт

- ❖ Багшийн хөгжлийн дэвтрийг тогтмол цаг тухай бүрт нь хөтөлдөг
- ❖ Цэнэглэх цаг болон, жижүүр багшийн хуудсаа багш хөгжлийн дэвтэртээ нааж тэмдэглэдэг
- ❖ Багшийн хөгжлийн дэвтрийг өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын дагуу хөтлөн, хийсэн ажлаа дүгнэн бичиж, цаашид төлөвлөж байгаа ажлаа бичиж тэмдэглэж байлаа.
- ❖ Хийсэн ажлаа цаг тухайд нь бичиж байвал хэрэгтэй болохыг ойлголоо.
- ❖ Дэвтрийн хөтлөлтийг сургалтын албанд дүгнүүлж байсан.

10. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

- ❖ Хичээлээс сурлагаар хоцрогдсон сурагчидтай ганцаарчлан ажилладаг.
- ❖ Хоцрогдолтой сурагчдад Багш Эцэг эхтэй нь уулзаж хамтран хоцрогдол болон улсын болон явцын шалгалтуудад амжилттай оролцоход нь эцэг эх багш сурагчын гурвалсан гэрээний дагуу хамтран ажиллаж байна.

I. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх

1. Сонирхлын судалгаа

- Хэлний чадваруудын сонирхлын судалгаа
- Эцэг эхийн оролцооны талаарх судалгаа

1. Сонирхлын судалгаа

№	Сонирхол	Сурагчдын тоо
1	Бүжиглэх	5
2	Дуулах	15

3	Хөгжим тоглох	5
4	Зураг зурах	10
5	Аялах	25
6	Гадаад хэлээр хичээллэх	35
7	Спорт	15
8	Загвар, дизайн	10
9	Гар урлал	5

Сурагчдынхаа сонирхол дээр тулгуурлан ажиллахад анхаарах болно.

2. Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа

№	Дугуйлан секцийн нэр	Тоо
1	Физик	1
2	Хими	1
3	Волейбол	2
4	Жудо, Триатон	4
5	Ширээний теннис	2
6	Сагсан бөмбөг	4
7	Шатар	1
8	Төгөлдөр хуур	2
9	Морин хуур	1
10	Шүлэг Хос Уянга	16
11	Бүжиг	3
12	Жүжиг драм	1
13	Загвар	1
14	Бассейн	1
15	Зураг	1
16	Математик	6
17	Орос хэл	7
18	Англи хэл	8
19	Компьютер	1
20	СӨУБ	17

2. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх

- ❖ Сурагчдаар сард нэг удаа дуртай орос номыг нь уншуулж ярилцдаг
- ❖ Уншсан номын тэмдэглэлийн дэвтэр хөтлүүлж хэвшсэн
- ❖ Ангийн номын сангийн баяжилт Үүнд:

3. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал

4. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал

- ❖ Олимпиад уралдаан тэмцээн
- ❖ /Олон улс, Улс нийслэл, дүүрэг, сургууль/ Үндсэн хэлний бөгөөд стандарт ангийн сурагчдыг олимпиадад бэлтгэн амжилт үзүүлсэн. Үүнд: Сурагчдын гаргасан амжилт
- ❖ Орос хэлний дүүрэг, нийслэлийн олимпиадад 9а ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулсан, мөн өөрөө амжилттай оролцсон.
- ❖ Дүүргийн Орос хэлний олимпиадад 9а ангийн сурагч Б.Пунцагмаа 1р байр “Алтан” медаль
- ❖ О.Намуунбилэг 2р байр “Мөнгөн” медаль
- ❖ Э.Дөлгөөн 3р байр “Хүрэл” медаль
- ❖ А.Амирлан шагналт 4р байр тус тус эзэлсэн болно.
- ❖ Нийслэлийн Орос хэлний олимпиадад Б.Пунцагмаа шагналт 4р байр эзэлж Улсын Орос хэлний олимпиадад орж “Батламж” авсан.
- ❖ Халимагийн Их Сургуулийн Орос хэлний Олимпиадад 9а ангийн сурагч Б.Пунцагмаа 1р байр “Алтан” медаль
- ❖ Халимагийн Их Сургуулийн Орос хэлний олимпиадад 9а ангийн сурагч О.Намуунбилэг 2-р байр “Мөнгөн” медаль
- ❖ 7а, 9а, 10а, 11а, 12а ангийн сурагчид “Читаем Пушкина на разных языках” уралдаанд Монгол, Орос, Англи, Япон, Солонгос, Хятад хэл дээр уншиж оролцсон болно. Тус уралдаан сургууль дээр РЦНК дээр тус тус болсон.

5. Бүтээлч ажил

- ❖ “Солнышко 1” сурах бичиг, дасгал ажлын ном, “Солнышко 2” сурах бичиг, дасгал ажлын номын редактороор ажилласан.
- ❖ Сурагчдыг номын тэмдэглэлийн дэвтэртэй болгосон.
- ❖ Сурагчдын ярианы цагийг гаргаж ярианы чадварын хөгжүүлэхэд анхаарч байна.
- ❖ Сурагч бүр шинэ үгийн хувийн толь бичгийг өөрсдөөр хийлгэн ашиглуулдаг.
- ❖ Эцэг эх сурагчдын харилцааны дэвтрийг нээн эцэг эхтэй харилцдаг.

6. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал
 - ❖ 7 хоногт 1 удаа багийн хичээл зохион байгуулж ярианы чадварыг сайжруулдаг.
7. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал
 - ❖ Гадаад хэлний мэдлэгээ ахиулахын тулд суралцдаг.
 - ❖ Орос англиас гадна өөр хэл бие даан суралцаж эхэлж байгаа
 - ❖ Илтгэлийн уралдаанд идэвхитэй оролцож мэргэжлийн мэдлэг ойлголтоо дээшлүүлдэг.
 - ❖ Мүүдл системийн сургалтанд сууж, хичээлийн хөтөлбөр, тест, даалгавар оруулахад суралцсан.
 - ❖ Мөн дотоод сүлжээнд дүн оруулах
 - ❖ Хичээлээ цахим хэлбэрээр бэлтгэн зааж байна
 - ❖ Сургуулийн захиргааны зүгээс багш нарын мэдлэг чадварыг цэнэглэх, эрүүл амьдрал, нийгмийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхуулах зорилготой зохион байгуулдаг “Цэнэглэх цаг”-т оролцож байсан.

II. Боловсролын сэтгэл ханамж

1. Цаг ашиглалт
 - ❖ Хувийн цаг ашиглалт, хувиар гарган ажилладаг .
 - ❖ Хичээл эхлэхийн өмнө хичээлээ бэлтгэдэг.
 - ❖ Тухайн хичээлийн жилд заах ёстой 997 цагийн хичээлийг таслалтгүй заасан.
 - ❖ Хичээл заах, цаг үеийн хурал шуурхайд оролцох, цэнэглэх цагт суух, журнал бичих, дэвтэр засах, тест засах, ангиа цэвэрлүүлэх, ангиа тараах
 - ❖ Олимпиад, уралдаан тэмцээнд сурагчдыг бэлтгэх
 - ❖ Эцэг эхийн хурал хийх
 - ❖ Эцэг эхтэй ганцаарчлан уулзаж, арга зүйн зөвлөгөө өгөх
 - ❖ Мүүдл сургалтанд хамрагдах, тест, даалгавар оруулах
 - ❖ Судалгаа авах
 - ❖ Хоцрогдсон сурагчидтай ажиллах
 - ❖ Секцийн хурал, үйл ажиллагаанд оролцсон.
 - ❖ Цахим хичээл бэлтгэн хичээлээ зохион байгуулдаг.
2. Сэтгэл ханамжийн судалгаа
 - ❖ Эцэг эхээс “Эцэг эхийн оролцооны талаарх ” судалгаа авсан
 - ❖ Сурагчдаас судалгаа авсан
 - ❖ Эцэг эхчүүдээс авсан судалгаа нь орос хэлний хичээл дээр ярих чадварт түлхүү анхаарах шаардлагатай гэдэг дээр олон санал гарсан.
3. Хичээлийн цагийн хариуцлага-40 минут

- ❖ Хичээлийг цагтаа эхэлж, цагтаа дуусгах, 40 минутыг үр бүтээлтэй, чанартай хариуцлагатай зохион байгуулдаг.
4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт
- ❖ Багшийн ёс зүй, хууль эрх зүйг баримтлан ажиллалаа.
5. Багшийн хичээлийн бэлтгэл
- ❖ Ээлжит хичээлийн бэлтгэлийг хийн, чанартай боловсролын үйлчилгээг ханган ажиллалаа.
 - ❖ Нэгж хичээлийн хөтөлбөрийг улирал бүр боловсруулан сургалтын менежерээр батлуулан сургалтаа явууллаа.
6. Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн
- ❖ Хичээл цагаар тасалдаг сурагчдын эцэг эхтэй уулзан шаардлага тавьж эцэг эх харилцааны дэвтрийг ажиллуулан хамтран ажилладаг
 - ❖ Хоцорсон хичээлийг нь нөхөхийн тулд өглөө хичээлийнх нь өмнө ирүүлж давтлага хичээл хийж нөхсөн
 - ❖ “Эртэч хүүхэд -2” аяны хүрээнд бүх сурагчид хоцролт таслалтгүй болсноос гадна улсын шалгалтанд амжилттай оролцоход нөлөөлсөн.
7. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал
- ❖ Багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтрийг чиглэл бүрээр хөтөлж тэмдэглэсэн. Багшийн хөгжлийн дэвтрийг хөтөлсөн.
 - ❖ Сурагчийн хувийн хэргийг журмын дагуу хөтлөн хичээлийн жилийн эцэст сургалтын менежерээр хянуулан баталгаажуулж байна.
 - ❖ Ээлжит болон нэгж хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг цаг тухай бүрт нь хийж батлуулдаг.
 - ❖ Журналыг сургалтын менежерээсээ зөвлөгөө авч зохих журмын дагуу хөтөлдөг.
8. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал
- ❖ Цахим хичээлийг бэлтгэн явуулж байсан.
 - ❖ Мүүдл системд хичээл оруулсан.
 - ❖ Ангийн зурагтыг HDMI холболтоор холбон мэргэжлийн багш нарт цахим хичээл заах боломжийг хангасан.
9. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт
- ❖ Хичээлийн явцад эрсдэлтэй зүйл ажиглагдвал тухайн ангийн багшид хандан шийддэг.
10. Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал

- ❖ Анги хамт олон, сурагч бүр аливаа үйл ажиллагаанд оролцсон үнэлгээг өөрсдөөр нь хийлгэх, түүндээ дүгнэлт хийх чадварт сургахыг зорин ажиллалаа.

III. Эрүүл мэнд

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа

- ❖ Хичээл болгоныг мэндлэн эхлүүлдэг
- ❖ Багш, ажилчидтай мэндлэх
- ❖ Тэдний хийж байгаа ажлыг хүндэтгэн харилцах
- ❖ Багш, сурагчийн хооронд эрүүл харилцааг бүрдүүлэхэд чиглэн ажиллалаа.
- ❖ Ангийн жижүүрийг ухамсарлан хийх, өөрсдийн сурч байгаа орчингоо цэвэр тохитой байлгах тал дээр тогтмол шаардлага тавин ажилласан /ангийн ариун цэврийн асуудал/

2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

- ❖ Хичээлийн явцад сурагч бэртэж гэмтэх тохиолдолд анхан шатны тусламж үзүүлж, шаардлагатай бол эмчид ханддаг.
- ❖ 4-р цагийн завсарлагаанаар сурагчдын хамт гимнастик хийж хэвшсэн.
- ❖ Сурагчид өдөр бүр суудлаа хойноосоо урагш урсан сууснаар тэдний хичээлд оролцох идэвхи сайжирсан.
- ❖ Зөв, тэгш суухыг зөвлөдөг.
- ❖ Дүрэмт хувцас бүрэн өмсөх
- ❖ Охидууд сургууль дээр үсээ тогтмол бооход анхаарч шаардлага тавин хэвшүүлсэн.
- ❖ Сурагчдын өндөр, жин үзэх үзлэгт хуваарийн дагуу хамруулсан.
- ❖ Ангийн сурагчид улаан бурхан өвчний вакцинд хамрагдсан.
- ❖ Ангийн эд хогшил, ширээ сандлыг ариг гамтай эдэлж хэрэглэхэд анхаарсан. Ангийн сурагчид өөрсдийн хэрэглэж буй ширээ сандлаа хариуцсан.

3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн

- ❖ Хичээлтэйгээ уялдуулан эрүүл мэндийн зөвлөгөө өгдөг
- ❖ Улаан бурхан, улаанууд өвчнөөс урьдчилан сэргийлэх 10-18 насны хүүхдэд хийх нэмэлт дархлаажуулалтын вакцин хийх улс орон даяар явагдаж буй аяны талаар мэдээлэл
- ❖ Охидын эмч Баярмаагийн зөвлөмж, хичээл
- ❖ Олон улсын хэрэглэгчийн эрхийн өдөр-Ухаалаг аюулгүй бараа бүтээгдэхүүн PPT хичээл
- ❖ Менингит өвчний тухай, түүнээс урьдчилан сэргийлэх арга замууд зурагт хуудас, зөвлөмж
- ❖ Томуу, томуу төст өвчний үед анхаарах зүйлс зөвлөмж зэрэг мэдээллийг эцэг эх, сурагчдад хүргэж ажиллалаа.

4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал
 - ❖ Хичээлийн эхэнд ангийн ариун цэвэрт анхаарч, хогийг нь авхуулан хичээлээ эхэлдэг
5. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал
 - ❖ Эрүүл орчны тухай дуу зааж, кино үзүүлэн утгыг нь ярилцан хичээлээ зохион байгуулсан
 - ❖ Үүний дүнд сурагчид хог хаяхаа больсон
6. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх
 - ❖ Жижүүр багш хийхдээ жижүүр ангийн сурагчидтай хамтран зохих шаардлага тавьж оролт, гаралтанд анхаарч ажилладаг.
7. Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал
 - ❖ Хичээл эхлэхийн өмнө ширээ сандлыг нь тэгшлүүлээд хичээл эхэлдэг.
8. Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал
 - ❖ Эрүүл мэндийн мэдлэгийг хичээлээрээ дамжуулан сурагчдад өгдөг.
9. Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
 - ❖ Хичээл болгоны эхэнд ангийн ариун цэвэрт анхааран, ширээ сандлыг нь тэгшлүүлэн, хогийг нь авхуулаад эхлэдэг.
10. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил
 - ❖ Сурагчдыг өвлийн амралтаараа шүдээ буюу амны хөндийг эрүүлжүүлэн эмчлүүлэх үүрэг даалгавар өгсөн.